

**СОГТУУРУУЛАХ УНДААНЫ ЗҮЙЛ ХЭРЭГЛЭСЭН ҮЕДЭЭ ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЭЛ ЖОЛООДСОН ЗҮРЧИЛ, ТҮҮНД ХҮЛЭЭЛГЭЖ БУЙ
ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ**

О.Ганбат. ДХИС-ийн “Хууль сахиулах удирдлага”
докторын хүтэглэлийн докторант

Товчлол: Замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах, гарч болзошгүй осол, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоо тэр тусмаа хуулиар хүлээсэн эрхээс гадна үүрэг, үүргээ биелүүлэх хариуцлага чухал төдийгүй энэ хариуцлагыг бий болгох механизмын гол хүчин зүйл нь шийтгэл оногдуулах хэлбэр юм. Тиймээс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил гаргаж буй этгээдэд хүлээлгэх хариуцлага, түүний үр нөлөөг дээшлүүлэх хэрэгцээ шаардлага байна. Энэхүү үзүүлэлтээр жолоочийн хариуцлага, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд хүлээлгэх хариуцлагын үр нөлөө, түүхэн болон гадаадын зарим орны туршлагыг харьцуулан судаллаа.

Төлхөөр үг: Замын хөдөлгөөний аюулгүй байдал, зөрчил, жолооч, жолоочийн хариуцлага, согтууруулах ундааны зүйл хэрэглэх, шийтгэл оногдуулах.

Удиртгал. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах Үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ”¹ гэж заасан бөгөөд 16.2 дахь хэсэгт “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль^{1 2}-ийн зорилт нь “Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх зүйн үндсийг тодорхойлж, холбогдох харилцааг зохицуулахад оршино” гэж заасан. Эдгээр заалтууд нь иргэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчил, ослоос ангид байж эрүүл, аюулгүй орчинд амьдрах, хамгаалуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн болох нь харагдаж байна. Уг хууль нь замын

¹ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.

² Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. // Төрийн мэдээлэл. №28, 2015 он.

хөдөлгөөний зохион байгуулалт, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, осол, хэрэг, зөрчлийг бууруулах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эрх ашгийг хамгаалах, жолоочийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зэл баримтлалаар 2015 онд шинэчлэн батлагдсан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа нь нийгмийн хөгжлийн зүй тогтлын дагуу олон хүчин зүйл болох эдийн засаг, улс төр, эрх зүй, соёл, хүн ам зүй, техник, технологийн хөгжлөөс хамааран хувьсан өөрчлөгдөж байна. Нийгмийн нийгэмд хамгийн их эрсдэл учруулж байгаа зүйл бол авто машины осол, аваар бөгөөд зөрчил гарахад согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, хамгаалалтын бус, малгай, аюулгүйн бус хэрэглэхгүй байх, хурд хэтрүүлэх, гар утсаар ярих, нөхрээ будах /эмэгтэйчүүд/, тамхи асаах, хөхөдтэйгээ зууралдах зэргээр анхаарал сарнихад жолоочийн хөдөлгөөн удаашрах, гэрэл дохио анхаарахгүй, эгнээ байр эзлэхдээ бусдыг анзаарахгүй байх, хажуу хоорондын зайг тохируулахгүй байх нь жолоочийн ур чадварт шууд нөлөөлдөг. Тиймээс энэ сэдвийг дараах үндэслэлээр авч судаллаа.

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчил, ослын нийгмийн байдал¹.

Хүснэгт №01. ЗХАБ-ын хууль тогтоомж зөрчсөн үзүүлэлт

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн зөрчил	Аймаг, дүүрэг	ОН				
		2016	2017	2018	2019	2020
	Улаанбаатар	1080168	1078800	1230074	1659618	1580126
	Орон нутаг	248392	245757	401922	548059	478221
	Улс	1328560	1324557	1631996	2207677	2058347

Улсын хэмжээнд 2016 онд 1328560 зөрчил бүртгэгдсэн бол 2020 онд 2058347 буюу 46 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн зам тээврийн осол 2016 онд 46712, 2017 онд 36591, 2018 онд 29474, 2019 онд 25302, 2020 онд 21768 тус тус буурсан үзүүлэлттэй байна. Эдгээр зөрчил, зам тээврийн осол гарахад нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь жолоочийн буруутай үйлдэл байдаг.¹

¹ Монгол Улс дахь Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. УБ., 2020 он.

Монгол Улсад сүүлийн 5 жилийн тээврийн хэрэгслийн тоо болон жолоочийн тоон зүүлэлтийг дараах хснэгтээр зүүлээ.

Хснэгт №02. Тээврийн хэрэгсэл, жолоочийн тоон сүүлийн 5 жилийн зүүлэлт¹

Он	Тээврийн хэрэгслийн тоо	Өсөлт, бууралт	Жолоочийн тоо	Өсөлт, бууралт
2020	1137208	9	1335000	5.4
2019	1043028	7.4	1265544	4.7
2018	970880	7.8	1207690	4.6
2017	900127	6.9	1153621	5
2016	841537	-	1098638	-

Дээрх хснэгтээс харахад 2016 онд тээврийн хэрэгсэл 841537 байсан бол 2020 онд 1137208 буюу 35.1 хувиар ссн зүүлэлттэй байна. Мн 2016 онд жолоочийн тоо 1098638 байсан бол 2020 онд 1335000 байсан нь 21.5 хувиар ссн байна. Эдгээр тоон зүүлэлтийг харьцуулан зэхэд тээврийн хэрэгсэл, жолоочийн тоон зүүлэлт зрчлийн тоон зүүлэлтэй шууд хамааралтай сж, буурна.

2. Монгол Улсад согтууруулах ундааны зйл хэрэглэсэн едээ тээврийн хэрэгсэл жолоодох асуудлыг таслан зогсоох, хариуцлагыг чангатгах арга хэмжээг хууль эрх зйлн зохицуулалтад тусган тухай бр шинэчилж ирсэн байдаг. Тухайлбал, БНМАУ-ын Ардын их хурлын тргүүлэгчдийн 1967 оны 1 дгээр сарын 17-ны 13 дугаар зарлигаар “Ууж согтууран автомашин өр явагч бусад машин механизм жолоодогчдод хлээлгэх хариуцлагыг чангатгах тухай”, мн 1974 оны 120 дугаар зарлигаар “Согтууруулах явдалтай хийх тэмцлийг хчтэй болгох тухай” шийдвэрлдийг гарган хариуцлага хлээх заалтуудыг тусган хэрэгжлж иржээ.

Захиргааны зрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага хлээлгэхтэй холбогдон өссэн харилцааг зохицуулах зорилго бхий Захиргааны хариуцлагын тухай хууль 1992 оны 11 дгээр сарын 27-ны өдр батлагдан хэрэгжиж улмаар 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуулиар хчингй болж, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдр батлагдсан “Зрчлийн тухай хууль”-иар замын хдлгний

¹ Тээврийн цагдаагийн алба. Монгол Улс дахь зам тээврийн осол, зрчлийн статистик зүүлэлтийн эмхэтгэл. УБ., 2020 он.

аюулгүй байдлын тухай хууль зэрчих бэлгийг шинэчлэн тусгаж
гсн. Энэ хуульд заасан согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн
үедээ тээврийн хэрэгсэл жолоодох зэрчилд хлээлгэх хариуцлага
тооцох асуудал нь жолоочийн хариуцлагыг нэмэгдлэх, дахин
зэрчил гаргахгүй байх, хариуцлагын р нлг дээшллэхэд
чиглэсэн.

Хснэгт №03. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ
тээврийн хэрэгсэл жолоодсон зэрчлийн слийн 5 жилийн злэлт:

Он	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зэрчил	Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ зам тээврийн осол гаргасан	Согтуу жолоочийн улмаас хүний амь хохирсон тохиолдол
2021	33404	1312	95
2020	26696	1103	112
2019	34591	978	150
2018	32335	799	135
2017	30532	793	96
Нийт	157558	4985	588

Монгол Улсын хувьд Ж.Авхиа, Б.Даваасамбуу¹ нарын нэг
сэдэвт бтээл, Г.Ренчиндорж^{1 2}, Д.Дгэрээ, Ж.Каукен³, А.Энхболд⁴
нарын бтээл, Х.Доржпалам⁵, Ч.Жаргалсайхан⁶, Д.Нямдорж⁷ нарын
докторын зэрэг горилсон бтээлд нийтийн хртээл болжээ.
Тнчлэн слийн жилдэд замын хдлгний аюулгүй байдал,
тний эрх зйн зохицуулалттай холбоотой цнгий магистрын⁸

¹ Авхиа Ж., Даваасамбуу Б.Авто тээврийн гэмт хэрэг.УБ. 1974

² Ренчиндорж Г. Зам тээврийн гэмт хэргийн нхцл байдал.УБ. 1985

³ Дгэрээ Д, Каукен Ж. Замын хдлгний аюулгүй байдлын ндэс.УБ. 1992

⁴ Энхболд А. Замын хдлгний аюулгүй байдал.УБ. 2007

⁵ Доржпалам.Х. Хдлгний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын
журам зэрчих гэмт хэрэгтэй тэмцэх эргийн эрх зй, криминологийн асуудал,
Хууль зйн ухааны доктор /Ph.D/-ын зэрэг горилсон бтээл.УБ. 2000

⁶ Жаргалсайхан.Ч. Жолоодлогын тусгай талбай ашиглан жолооч бэлтгэх
сургалтыг тглдлдржлэх нь. доктор /Ph.D/-ын зэрэг горилсон бтээл.УБ. 2002

⁷ Нямдорж Д. Монгол Улс дахь тээврийн хэрэгслийн ашиглалтын болон
хдлгний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг ослоос урьдчилан сэргийлэх
криминологийн шинж чанар. доктор /Ph.D/-ын зэрэг горилсон бтээл. Москва.
2009

⁸ Ган-Эрдэнэ.Г. Хнхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх онол,
практикийн зарим асуудал. Магистрын зэрэг горилсон бтээл. УБ, 2016,
Оюунгэрэл С. Цагдаагийн байгууллагаас замын хдлгний аюулгүй байдлыг

судалгааны ажлууд байна. Гэсэн хэдий ч жолоочийн өөрөг, хариуцлага, төлнийг нэмэгдүүлэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчил, төлнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн судалгааны ажил ховор байна.

Нийгэм, эдийн засгийн хурдацтай өөрчлөлтийн энэ цаг төд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой тодорхойлж, жолоочийн хариуцлагыг нэмэгдүүлэх, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн төдөө тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг бууруулах, шийтгэлийн хэлбэрийн оновчтой арга замыг тодорхойлох хэрэгцээ шаардлага байгаа нь харагдаж байна.

Энэхүү төгөөллийн зорилго нь жолоочийн хариуцлага, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчилд хөлээлгэх хариуцлагын өр нөлөө, төлхөн болон гадаадын зарим орны туршлагыг харьцуулан судалж, судалгааны эргэлтэд оруулах, хөгжүүлэх, практикт өр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэх явдал юм.

Тндсэн хэсэг. Цагдаагийн байгууллагаас Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дөрөм зөрчсөн зөрчилд гудамж замын хяналт, шалгалтаас гадна замын хяналтын камер болон цахим дөрс бичлэг ашиглан замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах, гарч болзошгүй осол, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж өдөр тутмын хяналтыг тавьж ажилладаг.

Замын хөдөлгөөнд оролцогчийн хэвийн, аюулгүй зорчих нөхцөлийг хангах, гарч болзошгүй осол, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоо тэр тусмаа хуулиар хөлээсэн эрхээс гадна өөрөг, өөргөө биелүүлэх хариуцлага чухал төдийгүй энэ хариуцлагыг бий болгох механизмын гол хөшөөрөг нь шийтгэл оногдуулах хэлбэр буюу замын хөдөлгөөнд оролцогч иргэдийн гаргасан зөрчилд мөнгөн торгууль оногдуулах, баривчлах, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг тодорхой хугацаагаар хасах, зөрчлийн оноо тооцох асуудал юм.

хангах эрх зүйн зохицуулалт, төлөнд хийх шинжилгээ. Магистрын зэрэг горилсон бөтөөл. УБ.,2016, Чинзориг Ц. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр нутгийн захиргааны байгууллагаас гаргасан захиргааны хэм хэмжээний актад хийсэн дөнгөн шинжилгээ. Магистрын зэрэг горилсон бөтөөл.УБ.,2017

Монгол Улсын их хурлаас 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр баталсан Зөрчлийн тухай хуулийн зорилго нь хууль төгөнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхийг зөрчилд тооцох, төгнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршдог.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд Монгол Улсын нутаг дэвсгэрт бэх нийтээр дагаж мөрдөх замын хөдөлгөөний нэгдсэн журмыг Замын хөдөлгөөний дөрмөөр тогтооно гэж заасан. Тэгвэл “Замын хөдөлгөөний дөрөм”-ээр тогтоосон замын хөдөлгөөний нэгдсэн журмыг зөрчсөн зөрчил 2020 онд улсын хэмжээнд 2058347 илрүүлснээс 76.8% нь нийслэлд, 30.3% нь орон нутагт бүртгэгдсэн байна. Эдгээрээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 26696, тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх, бичиг баримтгүй тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 13895, хөдөлгөөнд аюул учруулж болзошгүй бүрэн бус тээврийн хэрэгслээр хөдөлгөөнд оролцсон 226088, техникийн үлэг, оношилгоонд ороогүй, улсын дугааргүй техникийн гэрчилгээгүй 166316, хурд хэтрүүлсэн 150486, эгнээ байр буруу эзэлсэн 215659, бусад 1259207, цаашид хөдөлгөөнд оролцох боломжгүй 21378 тээврийн хэрэгслийг тэр саатуулж журамласан байна.

Бодит нөхцөл байдлаас харахад жил ирэх тутамд дээрх үзүүлэлт нэмэгдэж байгаа нь тээврийн хэрэгсэл, шинээр бэлтгэгдэж байгаа жолоочийн тоон үзүүлэлттэй шууд хамааралтай хэдий ч зөрчил гаргагчид оногдуулж байгаа шийтгэлийн үр нөлөө, жолоочийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, замын хөдөлгөөний дэг журмыг сахиулахад нөлөөллийн зөв хөшөөргийг бий болгох шаардлагатай байна.

Монголчуудын 1206 онд баталсан “Их засаг” хуульд: Албандаа анх удаа согтуу ирвэл тэр өдрийн барьсан зэвсгээр нь торго, хоёр дахь удаад нь унасан мориор нь торго, гурав дахь удаагаа болбол бие эрхтэнд нь халд /мөчийг нь огтол/, дөрвөн удаа давтал уг нутгаас зайлуул гэж хуульчилсан байжээ¹⁴. Үүнээс гадна 17-р зууны үеийн Ойрд Монголын хууль, 18-р зууны Халх журам

зэрэг хуульд архины хор холбогдлын талаар тодорхой заалт тусган оруулж, ногдуулах арга хэмжээг нь зааж "гс" н байжээ.

Халх журам хуульд 1724 онд нэмэлт "рчл" лт оруулж, Гэлэн х"н архи уувал гурван мориор, гэцэл х"н архи уувал 2 мориор, банди х"н архи хэрэглэвэл 1 мориор торгож, тэдний сахил санваарыг хурааж, торгуульд авсан морьдыг илрүүлсэн, гэрчилсэн х"нд "г" х, м"н архи уусан х"нийг нуун далдалсан х"нийг нэг мориор, архи "гс" н х"нийг 1 мориор торгодог журам тогтоожээ. "нтэй холбоотой архийг нэн чанга хориглон, цээрлэж байсны "р д"нд архидан согтуурах явдал "н" удаан жил бараг шахам байхг"й байсан уламжлалтай.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 07 дугаар сарын 02-ны "д"р "рш" л "з" лэх тухай хууль батлагдан гарснаар З"рчлийн тухай хуулийн 14.7 дугаар з"йл "Замын х" д" лг" ний аюулг"й байдлын тухай хууль з"рчих"-д заасан 2.804.816 з"рчлийн 66.517.100.000 /66 тэрбум 517 сая 100 мянган/ т"гр"гийн торгуулийг "рш" л "з" лэх тухай хуульд зааснаар энэ оны 10 дугаар сарын 01-ний "дрийг х"ртэл хугацаанд 50 хувийг "рш" н ч"л" лс"н. Энэ хуулийн х"рээнд тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ 2017 оны 07 дугаар сарын 01-нээс 2021 оны 06 дугаар сарын 24-ний "дрийн 24 цаг 00 минутаас "мн" З"рчлийн тухай хуулийн 14.7.3.1, 14.7.3.2, 14.7.13, 14.7.30, 14.7.32 дах заалтуудыг тус тус з"рчиж эрхээ хасуулсан 40531 жолоочийн мэдээллийг давхардааг"й тоогоор жолоочийн мэдээллийн санд "эрх хасагдсан" т"л"вийг х"чинтэй т"л"вт шилжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлаас "рш" л "з" лэх тухай" хуулийг баталж гаргасан нь з"рчлийг дахин давтахг"й байх, хариуцлага, эрх "ргээ ухамсарлахад чиглэсэн н"л"ллийн томоохон авч хэрэгжүүлсэн арга хэмжээний нэг т"дийг"й т"р ард иргэддээ итгэл "з" лж байгаа асуудал гэж нэг талаас харж болох юм. Харин н"г" талдаа ард иргэд маань энэ байдлыг угаас ингэх ёстой мэтээр д"гнэж "рийн "йлдэл эс "йлдлээс хамааран бусдын хуулиар олгогдсон эрхэд халдаж байгаагаа "л ухамсарлан, хариуцлага, хуулиар х"лээсэн "ргээ биелүүлэхийн оронд хэн нэгнээс бурууг хайсан, "рийн эрх "ргийг нэн тэрг"нд тавьсан байдал газар авч байгааг дурдах нь з"йтэй байх.

Гадаадын улс орнуудын согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон зүрчилд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог судалж үзэхэд: Австрали улсад бөх нийтийн баяр, амралтын үдрүүдэд Замын хүдэлгүүний дүрмийн зүрчил гаргасан этгээдэд ногдуулах шийтгэлийг хоёр дахин нэмэгдүүлэн хүлээлгэдэг заалт юм. Үүнд бусад шийтгэлээс гадна захиргааны шийтгэлүүд /эрх хасах, хорих гэх мэт/ нь хамаарагддаг. Австралийн хуулиар жолоочийн цусан дахь спиртийн агууламж 0.0.2-0.05 промилл /гэхдээ энэ хэмжээ зарим ангиллын эрх бөхий жолоочид зөвшөөрөгдөнө гэдгийг анхаарах хэрэгтэй/ 1100 хүртэл доллароор торгох ба 6 сараас дээш хугацаагаар эрх хасах шийтгэл оногдуулна;

Жолоочийн цусан дахь спиртийн агууламж 0.5-0.8 промилл байвал анх удаагийн тохиолдолд 1100 хүртэл доллароор торгож, 6 сараас дээш хугацаагаар эрх хасах шийтгэл оногдуулна. Мөн шүүхийн шийдвэрээр хорих ял оноох үндэслэлтэй байна;

Жолоочийн цусан дахь спиртийн агууламж 0.8-1.5 промилл байвал анх удаагийн тохиолдолд 2200 хүртэл доллароор торгож, 1 жилээс дээш хугацаагаар эрх хасахаас гадна 9 сар хүртэл хугацаагаар хорих бөгөөд харин давтан үйлдсэн тохиолдолд 3300 хүртэл доллароор торгож, 2 жилээс дээш хугацаагаар эрх хасахаас гадна 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ;

Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхээ шалгуулахаас зайлсхийсэн бол анх удаагийн тохиолдолд 3300 хүртэл доллароор торгож, 3 жилээс дээш хугацаагаар эрх хасахаас гадна 18 сар хүртэл хугацаагаар хорих бөгөөд харин давтан үйлдсэн тохиолдолд 5500 хүртэл доллароор торгож, 5 жилээс дээш хугацаагаар эрх хасахаас гадна 2 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ зэрэг заалтуудыг тусгасан байдаг.

АНУ-ын Калифорн мужийн замын хүдэлгүүний дүрмээр жолооч нарт согтууруулах ундааг балга түүдий хэрэглэсэн үедээ ч жолооны ард суухыг татгалзаж байхыг зөвлөмж болгоод 21 буюу түүнээс дээш насны жолоочийн цусан дахь спиртийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг дараах байдлаар тогтоосон.

- Энгийн тээврийн хэрэгсэл жолоодох үед 0.8 промилл;
- Ачааны тээврийн хэрэгсэл жолоодох үед 0.4 промилл;

Харин 21 нас хэрэггүй жолоочийн хувьд 0.1 промилл байхаар тогтоожээ. Энэ тогтоосон хэмжээг хэтрүүлэхгүй л бол тээврийн хэрэгсэл жолоодож болно гэсэн г хараахан биш бөгөөд хамгийн гол нь тухайн жолооч тээврийн хэрэгслээ аюулгүй жолоодох чадвараа алдаагүй байх нь чухал байдаг. Учир нь спиртийн зөвшөөрөгдөх хэмжээ нь хүн бүрд харилцан адилгүй нөлөөлдөг байна.

Хэрэв дээрх хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд шүүхийн шийдвэрээр дараах шийтгэлийг оногдуулдаг.

- 48 цагаас 6 сар хүртэл хугацаагаар хорих;
- 390-1000 доллароор торгох;
- Жолоодох эрхийг 6 сараар хасах;
- Жолоодож явсан тээврийн хэрэгсэл нь өөрийнх нэр дээр бүртгэлтэй байвал уг тээврийн хэрэгслийг 6 сар хураан авч, журмын хашааны зардлыг төлүүлэх;

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон дээрх зөрчлийг 7 жилийн дотор давтан үйлдвэл илүү хатуу шийтгэл хүлээлгэдэг байна. Үүнээс гадна согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодоход нь саад хийгээгүй буюу хүхэрлэн дэмжсэн этгээдийг мөн захиргааны хариуцлагад татдаг ажээ.

Арабын Эмират улсад согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодохыг хатуу хориглоно. Өөрөөр хэлбэл согтууруулах ундааны зөвшөөрөгдөх хэмжээ гэсэн ойлголт байхгүй. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож яваад зам тээврийн осол гаргасан бол даатгалын нөхөн төлбөр авах нь байтугай өндөр хэмжээний торгуулийн төлбөрт унаж, тэр бүү хэл хорих ялаар ч шийтгүүлж болзошгүй байдаг.

Дүгнэлт. Тээврийн цагдаагийн албанаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн олон ажил арга хэмжээг цаг хугацааны хувьд харилцан адилгүй байдлаар зохион байгуулж ирсэн. Гэсэн хэдий ч улсын хэмжээнд зам тээврийн осол, зөрчлийн 97.9% нь жолоочийн буруутай үйлдлээс улбаатайгаар гарч байгаа нь нэг талаараа жолоочийн эрх олгох сургалтын чанар, нөгөө талаараа жолооч нарын ухамсар муу, хөдөлгөөний соёл төлөвшиж чадаагүй, өөрэг хариуцлагаа ухамсарлахгүй байгаатай холбон

Эзж болохоор байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад жолоочийн гэрэг, хариуцлагыг зохицуулсан хууль, эрх зүйн орчин зохих хэмжээгээр бөрдсэн ч түүний хэрэгжилт, үр нөлөөг тодорхойлж, судлах шаардлагатай. Мөн согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг бууруулах, зөрчил үйлдсэн этгээдийг дахин тус зөрчлийг гаргуулахгүй байхад анхаарах шаардлагатай байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад жолоочийн гэрэг оролцоог нэмэгдүүлэх сайжруулах асуудлын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, өөрөөр хэлбэл, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон этгээдэд хөдөөлгөх хариуцлагыг нэмэгдүүлэх;
2. Түүрийн болон түүрийн бус байгууллагын алба хаагч, ажилчдад архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох хор уршгийн талаар ойлгуулах чиглэлээр нөөлөөллийн сургалт тогтмол явуулах;
3. Олон нийтийн цахим сүлжээг ашиглан энэ түүрийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл болон бодит учирсан хохиролтой баримтат киног тогтмол үзүүлж байх.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Монгол Улсын үндсэн хууль. Түүрийн мэдээлэл. 1992 №01.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль./Шинэчилсэн найруулга/. Түүрийн мэдээлэл. 2015 оны №28

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль. Түүрийн мэдээлэл. 1996 оны №7

Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/. Түүрийн мэдээлэл. 2017 оны №24

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2019-2023/. Түүрийн мэдээлэл. 2019 оны №34

Жолоочийн зөрчлийн бөртгэлийн оноо тооцох журам. Хууль зүйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 28-ны үдрийн а/187 дугаар тушаалын хавсралт. <https://legalinfo.mn/mn/detail/11296>

Монгол Улс дахь Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. УБ., 2020 он.

Авхиа. Ж, Даваасамбуу. Б. Авто тээврийн гэмт хэрэг.УБ. 1974
Ренчиндорж Г. Зам тээврийн гэмт хэргийн нөхцөл байдал.УБ.

1985

Дугээрээ.Д, Каукен.Ж. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын
төндөс.УБ. 1992

Энхболд А. Замын хөдөлгөөний аюулгүй байдал.УБ. 2007

Доржпалам.Х. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн
хэрэгслийн ашиглалтын журам зэрчиг гэмт хэрэгтэй тэмцэх
эрүүгийн эрх зүй, криминологийн асуудал, Хууль зүйн ухааны
доктор /Ph.D/-ын зэрэг горилсон бөгөөд.УБ. 2000

Жаргалсайхан.Ч. Жолоодлогын тусгай талбай ашиглан
жолооч бэлтгэх сургалтыг төгсгөлдөржүүлэх нь. доктор /Ph.D/-ын
зэрэг горилсон бөгөөд.УБ. 2002

Нямдорж.Д. Монгол Улс дахь тээврийн хэрэгслийн
ашиглалтын болон хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
ослоос урьдчилан сэргийлэх криминологийн шинж чанар. доктор
/Ph.D/-ын зэрэг горилсон бөгөөд. Москва. 2009

Ган-Эрдэнэ.Г. Хөдөлгөөнийг зам тээврийн ослоос урьдчилан
сэргийлэх онол, практикийн зарим асуудал. Магистрын зэрэг
горилсон бөгөөд. УБ, 2016, Оюунгэрэл С. Цагдаагийн
байгууллагаас замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах эрх
зүйн зохицуулалт, төгсгөлд хийх шинжилгээ. Магистрын зэрэг
горилсон бөгөөд. УБ.,2016, Чинзориг Ц. Замын хөдөлгөөний
аюулгүй байдлыг хангах чиглэлээр нутгийн захиргааны
байгууллагаас гаргасан захиргааны хэм хэмжээний актад хийсэн
дүн шинжилгээ. Магистрын зэрэг горилсон бөгөөд. УБ., 2017